



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/75/НА-СТА-ТШЗ

| | |
|-----------------------|---|
| Баянхонгор 2022 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: В.Наранцэцэг Утас: 88089024 Цахим хаяг: Naaaa_2463@gmail.com Цахим хуудас: www.audit.mn |
|-----------------------|---|

Агуулга

| | |
|---|----|
| 1.Аудитын гэрчилгээ /эх хувь/ | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 3. Аудитын тайлан | 11 |
| 3.1 Ерөнхий зүйл | 11 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 12 |
| 3.4 Материаллаг байдал | 12 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 12 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 13 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 14 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 14 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 14 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 4. Аудитын илрүүлэлт | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/96

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>81,635,915.16</u> | <u>90,451,508.04</u> |
| 33 | АВЛАГА | 1,520,000.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 1,520,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,520,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 80,115,915.16 | 90,451,508.04 |
| 351 | Түүхий эд материал | 64,919,964.98 | 70,376,034.86 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 63,666,464.98 | 69,549,484.86 |
| 35130 | Эм боох материал | 1,253,500.00 | 826,550.00 |
| 354 | Хангамжийн материал | 15,195,950.18 | 20,075,473.18 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 394,900.00 | 415,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,873,750.00 | 5,720,935.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,479,600.18 | 2,099,900.18 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,447,700.00 | 11,838,738.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,209,580,085.18</u> | <u>1,184,972,053.01</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,209,580,085.18 | 1,184,972,053.01 |
| 392 | Биет хөрөнгө | 1,204,830,085.18 | 1,180,222,053.01 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,186,366,712.00 | 1,185,963,912.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -22,247,427.20 | -44,921,395.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 42,789,360.00 | 50,566,260.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,511,852.17 | -28,224,706.18 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,702,667.74 | 66,934,978.54 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -47,269,375.19 | -50,096,996.35 |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,750,000.00 | 4,750,000.00 |
| 39301 | Програм хангамж | 100,000.00 | 100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -100,000.00 | -100,000.00 |

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|------------|---|--------------------------------|--------------------------------|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,750,000.00 | 4,750,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,291,216,000.34</u> | <u>1,275,423,561.05</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,291,216,000.34</u> | <u>1,275,423,561.05</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,291,216,000.34 | 1,275,423,561.05 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 70,793,223.00 | 70,793,223.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 70,793,223.00 | 70,793,223.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 981,746,942.47 | 965,954,503.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 981,746,942.47 | 981,746,942.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -15,792,439.29 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 238,675,834.87 | 238,675,834.87 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,291,216,000.34</u> | <u>1,275,423,561.05</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-
2А**

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | /Төгрөгөөр/ | |
|---------------|--|-----------------------|-----------------------|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 332,225,404.00 | 306,284,187.74 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 38,656,104.00 | 7,995,412.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 38,656,104.00 | 7,995,412.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 38,656,104.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 38,656,104.00 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ | | 2,275,00.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | | 5,720,412.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 293,569,300.00 | 298,288,775.74 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 251,144,800.00 | 264,911,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 251,144,800.00 | 264,911,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,874,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,874,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 34,550,500.00 | 33,376,875.74 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,550,500.00 | 33,376,875.74 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 326,171,433.12 | 321,975,926.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 326,171,433.12 | 321,975,926.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 296,389,534.89 | 287,726,974.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 180,770,680.77 | 180,475,519.00 |
| 210101 | Үндсэн цалин | 180,770,680.77 | 146,762,665.96 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 19,287,546.04 |

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|---------------------|-----------------------|
| 210104 | Урамшуулал | 00.00 | 14,425,307.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,273,462.00 | 24,450,048.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,511,221.00 | 17,467,836.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,601,624.00 | 1,725,598.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,203,028.00 | 1,364,376.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 311,514.00 | 353,460.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,646,075.00 | 3,538,777.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,473,831.00 | 31,878,275.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,430,091.00 | 1,323,163.74 |
| 210302 | Түлш, халаалт | 27,533,040.00 | 28,756,112.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 510,700.00 | 1,799,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,692,141.52 | 7,309,689.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 205,000.00 | 163,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 849,912.00 | 747,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,443,028.00 | 1,155,297.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 393,400.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 628,800.00 | 674,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,172,001.52 | 4,448,542.12 |
| 2105 | Нормативт зардал | 16,604,888.00 | 7,892,116.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 293,500.00 | 1,070,650.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,311,388.00 | 6,821,466.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 00.00 | 910,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 910,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 53,000.00 | 84,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 53,000.00 | 84,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 790,000.00 | 1,248,195.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 790,000.00 | 665,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 233,195.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,731,531.60 | 33,478,831.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 304,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,626,300.00 | 760,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,105,231.60 | 32,414,231.93 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29,781,898.23 | 34,248,951.98 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,974,000.00 | 94,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,874,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | 94,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,260,669.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,260,669.00 | 00.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 17,547,229.23 | 34,154,351.98 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,547,229.23 | 34,154,351.98 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 6,053,970.88 | -15,691,739.05 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 816,914,120.04 | 100,700.24 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 816,914,120.04 | 100,700.24 |

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|---|--|-------------------------------|------------------------------|
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -816,914,120.04 | -100,700.24 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-810,860,149.16</u> | <u>-15,792,439.29</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>293,569,300.00</u> | <u>298,288,775.74</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>293,569,300.00</u> | <u>298,288,775.74</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 251,144,800.00 | 264,911,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 251,144,800.00 | 264,911,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,874,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,874,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 34,550,500.00 | 33,376,875.74 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,550,500.00 | 33,376,875.74 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>292,119,300.00</u> | <u>292,656,875.74</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | <u>292,119,300.00</u> | <u>292,656,875.74</u> |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | <u>262,337,401.77</u> | <u>258,407,923.76</u> |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 180,770,680.77 | 180,475,519.00 |
| 210101 | Үндсэн цалин | 139,733,106.40 | 146,762,665.96 |
| 210102 | Нэмэгдэл | 25,430,914.37 | 19,287,546.04 |
| 210104 | Урамшуулал | 15,606,660.00 | 14,425,307.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,273,462.00 | 24,450,048.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,511,221.00 | 17,467,836.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,601,624.00 | 1,725,598.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,203,028.00 | 1,364,376.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 311,514.00 | 353,460.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,646,075.00 | 3,538,777.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,473,831.00 | 31,878,275.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,430,091.00 | 1,323,163.74 |
| 210302 | Түлш, халаалт | 27,533,040.00 | 28,756,112.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 510,700.00 | 1,799,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,810,140.00 | 6,180,201.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 91,900.00 | 184,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 849,912.00 | 747,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,443,028.00 | 1,152,666.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 51,100.00 | 345,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 393,400.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 980,800.00 | 3,630,285.00 |
| 2105 | Нормативт зардал | 20,013,388.00 | 7,889,166.00 |

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,547,000.00 | 643,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,311,388.00 | 6,821,466.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,155,000.00 | 424,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,336,000.00 | 2,449,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,520,000.00 | 806,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 816,000.00 | 1,643,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 53,000.00 | 84,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 53,000.00 | 84,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 790,000.00 | 1,250,826.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 540,000.00 | 665,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 235,826.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,816,900.00 | 3,750,288.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2,899,288.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,816,900.00 | 851,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29,781,898.23 | 34,248,951.98 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,974,000.00 | 94,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,874,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | 94,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,260,669.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,260,669.00 | 00.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 17,547,229.23 | 34,154,351.98 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,547,229.23 | 34,154,351.98 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>1,450,000.00</u> | <u>5,631,900.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | <u>1,450,000.00</u> | <u>5,631,900.00</u> |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | <u>1,450,000.00</u> | <u>5,631,900.00</u> |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | <u>1,450,000.00</u> | <u>5,631,900.00</u> |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,450,000.00 | 5,631,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-1,450,000.00</u> | <u>-5,631,900.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| С08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 70,793,223.00 | 238,675,834.87 | 981,746,942.47 | 00.00 | 1,291,216,000.34 |

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | |
|-----|---------------------------------------|---------------|----------------|----------------|-------|------------------|
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 70,793,223.00 | 238,675,834.87 | 981,746,942.47 | 00.00 | 1,291,216,000.34 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 70,793,223.00 | 238,675,834.87 | 981,746,942.47 | 00.00 | 1,291,216,000.34 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -15,792,439.29 | 00.00 | -15,792,439.29 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 70,793,223.00 | 238,675,834.87 | 965,954,503.18 | 00.00 | 1,275,423,561.05 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 305,322,800.00 | 264,134,423.76 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 305,322,800.00 | 264,134,423.76 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 305,228,200.00 | 264,039,823.76 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 193,925,100.00 | 180,475,519.00 |
| 210101 | Үндсэн цалин | 148,497,400.00 | 146,762,665.96 |
| 210102 | Нэмэгдэл | 19,621,100.00 | 19,287,546.04 |
| 210104 | Урамшуулал | 25,806,600.00 | 14,425,307.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,775,000.00 | 24,450,048.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,137,900.00 | 17,467,836.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,909,300.00 | 1,725,598.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,527,400.00 | 1,364,376.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 381,900.00 | 353,460.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,818,500.00 | 3,538,777.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 38,910,900.00 | 31,878,275.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,089,900.00 | 1,323,163.74 |
| 210302 | Түлш, халаалт | 34,021,000.00 | 28,756,112.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,799,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,009,100.00 | 6,180,201.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 185,100.00 | 184,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,350,000.00 | 747,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,376,200.00 | 1,152,666.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 347,300.00 | 345,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,630,500.00 | 3,630,285.00 |
| 2105 | Нормативт зардал | 26,421,000.00 | 7,889,166.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 644,100.00 | 643,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25,352,900.00 | 6,821,466.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 424,000.00 | 424,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,083,000.00 | 8,081,500.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 6,438,000.00 | 6,437,900.00 |

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210604 | Урсгал засвар | 1,645,000.00 | 1,643,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 88,300.00 | 84,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 88,300.00 | 84,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,264,300.00 | 1,250,826.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 674,300.00 | 665,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 235,826.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3751500.00 | 3750288.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,900,000.00 | 2,899,288.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 851,500.00 | 851,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94600.00 | 94600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 94,600.00 | 94,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 94,600.00 | 94,600.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 305,322,800.00 | 264,134,423.76 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 264,911,900.00 | 230,757,548.02 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 264,911,900.00 | 230,757,548.02 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 40,410,900.00 | 33,376,875.74 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 40,410,900.00 | 33,376,875.74 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 12.00 | 13.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 03.00 | 03.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 09.00 | 09.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор В.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Б.Баттулга нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын Цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 326171.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4892,5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3669.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3622.2 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1275423.6 мянган төгрөг болж өмнөх оноос 15792.4 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын материал, аж ахуйн материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Өлзийт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 81,635.9 | 90,451.5 | 8,815.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,520.0 | - | (1,520.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 80,115.9 | 90,451.5 | 10,335.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,209,580.1 | 1,184,972.1 | (24,608.0) |
| Үндсэн хөрөнгө | 1,302,708.7 | 1,308,315.2 | 5,606.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (93,128.7) | (123,343.1) | (30,214.4) |
| Нийт хөрөнгө | 1,291,216.0 | 1,275,423.6 | (15,792.4) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,291,216.0 | 1,275,423.6 | (15,792.4) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,291,216.0 | 1,275,423.6 | (15,792.4) |

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 90451.5 мянган төгрөг болж 10335.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 5883.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материалын дансны үлдэгдэл 2847.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1308315.2 мянган төгрөг болж 5606.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5631.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан, БСШУЯамнаас 2275.0 төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч, Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2021.12.28-ны 156 дугаар тогтоол, 2021.04.01-ний 43 тоот тогтоолоор нийт 2300.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1275423.6 мянган төгрөг болж өмнөх оноос 15792.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралтаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 489798.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 489798.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 177082.0 мянган төгрөгөөр бууруулж 312716.3 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 305322.8 мянган төгрөг болж 7393.5 мянган төгрөг буюу 2,4 хувиар буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 305322.8 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 264911.9 мянга, орон нутгийн төсвөөс 40410.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 264911.9 мянга, орон нутгийн төсвөөс 33376.9 мянга нийт 298288.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 264134.4 мянган төгрөгийг зарцуулж 34154.3 мянган төгрөг буюу 11,4 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 7034.0 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 264134.4 мянган төгрөг буюу 86,5 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 7032.6 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 13449.6 мянга, хүүхдийн хоолны зардал 18531.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Баян ташаагийн эх аудит” ХХК –ний аудитор Ч.Чимгээ санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 34 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 94 %-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 321975.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 4195.5 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамж, бараа материалын зардал, нормативд зардал буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээлэл мэдээлэхээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн 16069,6 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 264911.9 мянга, орон нутгийн төсвөөс 33376.8 мянга нийт 298288.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 264134.4 мянган төгрөгийг зарцуулж 34154.3 мянган төгрөг буюу 11,4 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 7034.0 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 40750.5 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 8150.1 мянган төгрөг байна.

Тус онд хийгдсэн зохицуулалтаар 1839.6 мянган төгрөгийг хасаж тодотгосон, тодотгосон төсвөөс 7032.6 мянган төгрөгийн, нийт 8872.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 47544.8 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй, 2 зөвлөмж өгсний хэрэгжилтийг 2021.06.14-ын 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____